



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн “Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн бүртгэсүгэй.
2. Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/-д үүрэг болгосугай.
3. Хавсралтад дурдсан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/, актуарч /С.Ерөөлт/-д тус тус анхааруулсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 12 сарын 16 өдрийн  
379-р тогтоолын нэгдүгээр хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

|     |  |   |
|-----|--|---|
| 1.  | Даатгалын компанийн нэр:   | “Тэнгэр даатгал” ХХК  |
| 2.  | Даатгалын бүтээгдэхүүний нэр:  | Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал  |
| 3.  | Хамаарах даатгалын хэлбэр:   | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал  |
| 4.  | Даатгалын зүйл   | Даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд  |
| 5.  | Даатгалын эрсдэл   | Үндсэн эрсдэл:<br>1. Үйлдвэрлэлийн осол;<br>2. Ахуйн осол;<br>3. Зам тээврийн осол;<br>4. Байгалийн үзэгдэл түүний улмаас үүссэн осол;<br>5. Гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.<br><br>Нэмэлт эрсдэл:<br>1. Тархинд цус харвах;<br>2. Зүрхний шигдээс. |
| 6.  | Даатгалын гэрээний хугацаа   | Харилцан тохиролцоно  |
| 7.  | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо                                 | 8 бүлэг, 114 заалт  |
| 8.  | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/28 тоот шийдвэр   |
| 9.  | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:                                   | С.Ерөөлт  |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:                                     | Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтсийн менежер Б.Мөрөн  |

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 12 сарын 16 өдрийн  
379-р тогтоолын хоёрдугаар хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

|     |  |  |
|-----|--|--|
| 1.  | Даатгалын компанийн нэр:   | “Тэнгэр даатгал” ХХК   |
| 2.  | Даатгалын бүтээгдэхүүний нэр:  | Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал  |
| 3.  | Хамаарах даатгалын хэлбэр:   | Хөрөнгийн даатгал  |
| 4.  | Даатгалын зүйл   | Даатгалын гэрээнд тусгагдсан буюу зээлээр худалдан авч, зээлийн барьцаанд тавьсан орон сууц  |
| 5.  | Даатгалын эрсдэл   | <ol style="list-style-type: none"> <li>1. Галын эрсдэл /гал түймэр, дэлбэрэлт/;</li> <li>2. Сантехникийн болон ус чийгний эрсдэл;</li> <li>3. Байгалийн эрсдэл /газар хөдлөлтийн эрсдэл хамаарахгүй/;</li> <li>4. Цахилгаан эрчим хүчний эрсдэл;</li> <li>5. Гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл.</li> </ol> |
| 6.  | Даатгалын гэрээний хугацаа   | Харилцан тохиролцоно   |
| 7.  | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо                                 | 8 бүлэг, 103 заалт   |
| 8.  | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/28 тоот шийдвэр  |
| 9.  | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:                                   | С.Ерөөлт   |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:                                     | Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтсийн менежер Б.Мөрөн   |